

**ГХБХБГ-ЫН 3 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.03.01.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Эзэмшил газрын талбайн хэмжээний зөрүүг арилгуулахыг хүссэн нэг иргэний хүсэлтийг холбогдох материалын хамт хүлээн авч Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан аймгийн ЗДТГ-рт хүргүүлсэн болно.</p> <p>Геодезийн мэргэжилтний хэмжилт хийсэн 3 иргэн 2 аж ахуйн нэгж байгууллага, “Өлгийланд” ХХК-ны хэмжилт хийсэн 1 аж ахуйн нэгж байгууллага 27 иргэний хашааны газрыг газрын кадастрын мэдээллийн санд оруулав. Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 14 газрын кадастрыг хянаж бүртгэлд оруулав.</p> <p>Аймгийн Захиргааны хэргийн шүүхээс нотлох баримт гаргуулах тухай ирүүлсэн албан тоотын дагуу холбогдох хариуг хүргүүлсэн.</p> <p>Сумдын тариалангийн газрын хянан баталгаа хийх 2018 оны бэлтгэл ажлыг хангах тухай сумдын Засаг дарга, даамал нарт хугацаатай албан даалгавар хүргүүлэв.</p> <p>Барилгын салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг тохиолдуулан Барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг 2018 оны 02 дугаар сарын 25-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Гар бөмбөгийн тэмцээнд нийтдээ 16 аж ахуйн нэгж байгууллага оролцож, Ганбарс ХХК нь 1 дүгээр байр, Монголын Цахилгаан Холбооны газар 2 дугаар байр, Дайчин хүлэг ХХК нь 3 дугаар байр шалгарсан болно.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Алтай сум:</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

Шинээр газарөмчлүүлэх 4 өргөдөл, шинээр газар эзэмшүүлэх 1 өргөдөл хүсэлтийг хүлээн авч бүртгэв.

Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвөлрүүлж байна.

12 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 програмын цахимд архивласан.

Алтанцөгц сум: 37 иргэний хувийн хэргийг сканердаж ЛМ-д оруулав.

4 иргэнд гэрээ хийж, гэрчилгээ олгож, байршлыг тогтоож координат авч ЛМ-д оруулж түр нэгж талбар үүсгэв.

Гэрчилгээ авсан 4 иргэнийг Улсын бүртгэлд бүртгэв.

Кадастрын өөрчлөлт хийж дуусгавар болгосон нэг иргэний материалыг ЛМ-д оруулан холбож өгөв.

10ш өргөдөл хүлээн авч танилцан захирамж төлөвлөв.

Баяннуур сум: 20 иргэнд Сумын засаг даргын захирамж гаргаж өмчлүүлсэн газрын хэмжээнд өөрчлөлт оруулав.

Аж ахуйн нэгж, ард иргэдээс 4 өргөдөл, гомдол, санал хүсэлт, хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэв.

Шинээр 2 иргэнд, Одоо эзэмшиж буй хашааны газрыг 1 иргэнд тус тус газар өмчлүүлэхээр сумын засаг даргын захирамж гаргаж, кадастрын зураг, хянан баталгаа болон бусад холбогдох материалыг бүрдүүлж өгөв.

Ажлын төлөвлөгөөний дагуу өдөр бүр дотоод ажиллаа хийж байна.

Газрын төлбөрийн төлөвлөгөөг гаргасан графикийн дагуу 2 дугаар сард 79000 мянган төгрөгийг бэлэн оруулав.

Булган сум: Энэ долоо хоногт иргэдээс ирсэн гомдлын

дагуу Ёлт багт очиж ажиллав. Үүнд тус 2 дугаар багийн иргэн Хавшан овогтой Сүндетбек, Хавшан овогтой Хайратбек нарын газрын маргааныг шийдвэрлэж ажиллав.

Бугат сум: Сумын Зөөлөнгийн эх, Шинэ даваа гэх газарт холбоо, мэдээлэл дамжуулах станцын байршилд координат тогтоож ирэв. Мөн 2 иргэний өргөдөл хүлээн авсан. 1 иргэнд үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлж өгөв.

Дэлүүн сум: 4-р багийн иргэн Х.Болатын өргөдлийн дагуу өвөлжөөний маргааныг газар дээр нь очиж шийдвэрлэж ирсэн. Мөн Сумын төвийн 2 иргэний өмчлөлийн газрыг ЛМ программд оруулан улсын бүртгэлийн газар үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авахаар материалыг хүргүүлэн ажиллав.

Толбо сум: Шинээр газар эзэмшигч иргэдэд гэрчилгээ олгож, улсын бүртгэлд тусган хувийн хэрэг шинээр нээж ажиллаж байна. Урьд нээсэн хувийн хэргийн дутуу материалыг хавсарган хувийн хэрэгт хадгалан ажиллав. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг тухайн бүрд хариу өгч ажиллав.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР